



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

Нэгдсэн эмнэлгийн байр-1, Сүхбаатар сум  
Сэлэнгэ аймаг, 43085; Утас/Факс: (976) 7036-3586  
Цахим шуудан: selenge.emg2@gmail.com  
Цахим хуудас: www.emg.se.gov.mn

2023. 10. 02 № 10-29-02/М/69

МАКСИМУМ ЛАЙН ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Д.МӨНХНАСАНД

**Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт  
хийсэн тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” 10-00/07 дугаартай удирдамжийн дагуу Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч М.Болормаа 2023 оны 09 дүгээр сарын 18-29-ны өдрийн хугацаанд “Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төслийн 4 дүгээр ээлжийн хүрээнд Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Б байрны ариун цэврийн байгууламжийн”-ын ажлын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийлээ.

**Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:**

Боловсролын Ерөнхий газрын хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Алтангэрэлийн захиалгаар ариун цэврийн байгууламжийн барилга архитектур, цэвэр бохир ус, халаалт агаар сэлгэлт, хүчит төхөөрөмж, дотор гэрэлтүүлгийн ажлын зургийг Максимумлайн ХХК-д боловсруулж архитектор Б.Жавхлантагс, инженер Б.Мөнх-Эрдэнэ, Ж.Нямбат, Г.Гантулга нар гарын үсэг зурж баталгаажуулсан.

Максимум лайн ХХК нь /РД: 5538246/ Барилга хот байгуулалтын яамны ЗТ16-1218/19 дугаартай гэрчилгээгээр баталгаажсан зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй байна. Ажлын зураг төслийн ЕГ шифр:МЛ-А3-23/010.

**Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:** Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Б байр /РД: 9056726/ нь Мандал сумын Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 410 тоот захирамжаар олгогдсон, 4303001434 дугаар бүхий “Боловсролын байгууллагын”-ын зориулалтаар 36988 м2 газрыг 15 жилийн хугацаатай ашиглах “Төрийн байгууллагын газар эзэмших эрх”-ийн гэрээ, гэрчилгээ, кадастрын зураглалтай байна.

**Зураг төслийн товч агуулга:** Мандал сумын 1 дүгээр багийн Өртөө 4 дүгээр гудамны С-1 тоот хаягт байрлах ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Б байр буюу 240 хүүхдийн суудалтай, бага сургуулийн одоо байгаа ариун цэврийн

000012



байгууламжид өөрчлөлт хийж 1 дүгээр давхарын ариун цэврийн өрөөг 3 том, бага насны хүүхдэд зориулсан 3, нийт 6 суултууртай болгож эмэгтэй сурагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө байхаар өөрчлөн төлөвлөсөн.

2 дугаар давхарын ариун цэврийн өрөөнд 3 ширхэг шээлтүүр, бага насны хүүхдэд зориулсан суултуур 2 ширхэгийг нэмж эрэгтэй сурагчдад зориулсан ариун цэврийн өрөө байхаар төлөвлөсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" БНБД 31-25-22 барилгын норм, дүрмийн дагуу бага сургуулийн ариун цэврийн өрөөг нэг сурагчид 0.1 м<sup>2</sup>-аас багагүй талбай оногдохоор тооцож нийт талбайг төлөвлөсөн.

Ариун цэврийн өрөөнүүд нь зориулалтын гар хатаагч төхөөрөмж, угаалтуур, суултуураар тоноглогдсон, суултуур бүр тусдаа тасалгаа бүхээгтэй, хаалгыг гадагш онгойхоор төлөвлөсөн.

Бага сургуулийн барилгын нэгдүгээр давхарын ариун цэврийн өрөөнд шинээр хана хийж тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан бие засах өрөөг гаргасан ба бүхээгийн хэмжээ, тэргэнцрээс бие засах суултуурын нэг талаас шилжин суух зай хангалттай, эргономикийн шаардлагад нийцсэн байна.

Төлөвлөж байгаа ариун цэврийн өрөөний угаалтуур, суултуурын шалнаас дээш дээд гадаргуугийн өндөр, өрөөний хаалганы онгойх нүхний хэмжээ, шалны түвшин, угаалтуур ба хана хоорондын зай, угаалтуур, суултуурын хоорондын зай хэмжээ зэрэг нь эрүүл ахуйн шаардлагыг хангаж байна.

Дээрх ариун цэврийн өрөөнүүдэд агаар сэлгэлтийн ердийн систем, механик сорох систем, сэнстэй сараалж төлөвлөсөн.

Ариун цэврийн өрөөнүүдэд ус чийгнээс хамгаалагдсан гэрэлтүүлэгчийг дүүжин таазны байгуулалттай уялдуулан төлөвлөсөн.

Ус хангамж: Мандал сумын төвлөрсөн усан хангамжийн системээс, одоо байгаа ариун цэврийн өрөөний шугамын уснаас хангагдахаар төлөвлөсөн. Ус хангамжийн хэрэгцээний халуун усыг 1 дүгээр давхарт 1,0 квт-ын 15 литрийн багтаамжтай эзэлхүүний ус халаагчаар, 2 дугаар давхарын хэрэгцээний халуун усыг 2,0 квт-ын 40 литрийн багтаамжтай эзэлхүүний ус халаагчаар тус тус халааж түгээхээр, төлөвлөсөн.

Бохир ус, ариутгах татуурга: Мандал сумын бохир ус, ариутгах татуургын төвлөрсөн системд, одоо байгаа ариун цэврийн өрөөний бохир усны босоо шугамд холбогдон зайлуулагдахаар төлөвлөсөн.

Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн ДҮГНЭХ НЬ: Максимум лийн ХХК-ийн боловсруулсан Сэлэнгэ аймгийн Мандал сумын Төмөр замын 1 дүгээр баг, Өртөө 4 дүгээр гудамны С-1 тоот хаягт байрлах ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн Б байрны ариун цэврийн байгууламжийн өөрчлөлтийн ажлын зураг төсөл нь Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалт, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйл, Олон нийт, иргэний барилга БНБД 31-03-03, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08, Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга, БНБД 40-05-16 стандарт, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 10 сарын 19-ний өдрийн 211 дугаар

тушаалын хавсралт "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт"  
БНБД 31-25-22 барилгын норм, дүрмийн шаардлагыг хангаж байна.

Гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол Улсын Төрийн  
хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад  
тусгагдсаны дагуу дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



М.БОЛОРМАА

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ЗАХИРАЛ

*Д. Мөнхнасан*

Д.МӨНХНАСАН